



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 5/63

Бор-Өндөр

Б.Эрдэнэзулаар ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйл, 109 дүгээр зүйлийн 109.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архив, бичиг хэргийн ажилтан Баатарын Эрдэнэзулаар 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны үүргийг хавсран гүйцэтгүүлсүгэй.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох дүрэм журмыг албан хаагчдад таниулан, байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан (Б.Эрдэнэзул)-д үүрэг болгосугай.
3. Б.Эрдэнэзулд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг цалингийн 40 хувиар тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ